



#### Дугаар №39



2018 оны 11-р сарын 19-25

### НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **1253** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 116(9.2%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1096(87.4%) хачигт халдвар, 24(1.9%) бэтэг, 2(0.1%) хумхаа, 10(0.8%) боом, 7(0.5%) тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

#### 1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын **1096** сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 13.7%-иар бага байна.



Хачигт риккетсиозын 816 сэжигтэй тохиолдлын 199(24.4%), хачигт энцефалитын 185 сэжигтэй тохиолдлын 32(17.3%), хачигт боррелиозын 95 сэжигтэй тохиолдлын 24(25.3%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдсан байна

#### 1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт **116** тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17.1%-иар буурсан байна



## ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

### Монгол улсад:

#### Мал, амьтны галзуу өвчин:

Говь-Алтай аймаг, Халиун сум, Сүүж багийн малчин “З”-ын хотонд 11 дүгээр сарын 16-ны өдөр мал, амьтны халдварт ”Галзуу” өвчний шинж тэмдэгтэй 1 буга орж ирснийг устгаж, дээж авч УМЭАЦЛ-д шинжлүүлэхэд “Галзуу” өвчин болох нь тогтоогдсон байна.

Хариу арга хэмжээ:

- Аймгийн ЗӨСТ, мал эмнэлгийн байгууллагатай хамтран мэдээ мэдээлэл солилцож ажиллаж байна. Голомтод хүн эрсдэлд өртсөн тохиолдол мэдээлэгдээгүй.
- Тус сумын Засаг даргын 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/102 дугаар захирамжаар хязгаарлалтын дэглэм тогтоосон. Хяналтын 2 цэгт 14 хүн, 3 автомашинтай ажиллаж 730 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн.

Эх сурвалж: ОБЕГ, Говь-Алтай ЗӨСТ

#### Мал, амьтны галзуу өвчин:

Хэнтий аймгийн Бэрх сумын 7-р багаас урагшаа 15 км-т орших “Амгалангийн жалга” гэх газар малчин “Т”-ийн 1 үхэр галзуу өвчнөөр өвчилсөн болох нь аймгийн Мал эмнэлгийн лабораторийн 18-242 тоот шинжилгээгээр батлагдсан байна.

Хариу арга хэмжээ:

- Тухайн голомтонд байсан 2 хүнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан голомтыг халдваргүйжүүлж, галзуу өвчнөөс сэргийлэх, сургалт сурталчилгааг зохион байгуулан ажиллаж байна.
- Хэнтий аймгийн Бэрх сумын Засаг даргын А/110 тоот захирамжаар 14 хоногийн хязгаарлалтын дэглэм тогтоон ажиллаж байна. Голомтын 2760 мал, 4 нохойг вакцинжуулахаар вакцин захиалсан байна.

Эх сурвалж: Хэнтий ЗӨСТ

#### Мал, амьтны галзуу өвчин:

Хэнтий аймгийн Хэрлэн, Галшар сумдын нутагт 2018 оны 11-р сарын 15-наас 11-р сарын 22-ны хугацаанд эзэнтэй 2, эзэнгүй 1 нохойд нийт 3 хүн уруулж ноцуулсан дүнтэй байна.

Хариу арга хэмжээ:

- Эзэнтэй нохойд 2 хүн, эзэнгүй нохойд 1 хүн уруулсан дүн мэдээтэй байна. Хүн урсан нохойг 14 хоног уяж ажиглаж байна.

Эх сурвалж: Хэнтий аймаг ЗӨСТ

## Олон улсад:

### Африкийн гахайн халуурал өвчин: ОХУ

ОХУ-ын Москва хот, Мал эмнэлэг, эрүүл мэнд, тандалт судалгааны албаны мэдээлснээр 2018 оны 11-р сарын 16-ны өдрийн байдлаар тус улсын (*Orankское, Bogorodsky, Nizhegorodskaya Oblast*) мужуудад африкийн гахайн халуурал өвчнөөр 1 зэрлэг гахай өвчилж үхсэн байна.




Эх сурвалж: ДАЭМБ

### Мал амьтны галзуу өвчин: Малайзын Холбооны Улс

Малайз улсын мал эмнэлгийн ерөнхий газрын мэдээлснээр 2018 оны 11-р сарын 19-ны байдлаар тус улсын (*Sarawak, Serian, Sri Aman, Kuching, Samarahan, Sarikei, Betong, Sibul, Kapit, Miri, Mukah, Bintulu*) мужид галзуу өвчнөөр 149 нохой өртөмхий байснаас 10 нохой өвчилж, 11 нохойг устгалд оруулсан байна.

Хариу арга хэмжээ: Масс дархлаажуулалтад нийт 96075 нохой, 8507 муурыг хамруулсан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

### Мал амьтны боом өвчин: Австрали улс

Австрали улсын Виктория мужийн хөдөө аж ахуйн яамнаас тус мужийн (*Swan Hill*) гэх фермийн хониноос боом өвчний үүсгэгч илэрсэн болохыг мэдээлсэн байна.


Хариу арга хэмжээ: Фермд хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоож, урьдчилан сэргийлэх зорилгоор 4300 мал, амьтан дархлаажуулалтад хамруулсан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

### Эбола вирус халдвар: БНАКУ

Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар Хойд Киву мужийн (*Mabalako, Beni, Kalunguta, Masereka, Butembo, Oicha, Musienene*), Итури мужийн (*Mandima*) эрүүл мэндийн төвийн мэдээлснээр эбола вирус халдварын нийт **386** тохиолдол бүртгэгдэж үүнээс **219** тохиолдол нас барсан байна.



Эх сурвалж: ДЭМБ

---

Энэ долоо хоногт **Архангай, Хэнтий, Өмнөговь, Багануур** аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн байна. Бусад салбар төвүүд ШУН-ийн [eop@nczd.gov.mn](mailto:eop@nczd.gov.mn), [nczd.eop@gmail.com](mailto:nczd.eop@gmail.com) хаяг руу мэдээгээ ирүүлж байна уу?

**ШУУРХАЙ УДИРДЛАГЫН НЭГЖ**